



ЭЗХНЗОГ-ЫН МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ДҮГНЭЛТ ТАЙЛАН - Оюу Толгой - 01 & 02/ӨМНӨГОВЬ, 2020 ОНЫ 5-Р САР

ОУСК болон ОТХОБА-ийн дэмжлэгийг авсан (ОУСК #29007 & ОТХОБА #7041), Монгол улс дахь Оюу Толгой төсөлтэй холбоотой хоёр гомдлын ЭЗХНЗОГ-аас чиглүүлсэн маргаан шийдвэрлэх үйл явцыг энэхүү тайланд товчхон дүгнэлээ.

ҮНДЭСЛЭЛ

ОУСК-ийн санхүүжилт

Оюу Толгой төсөл нь Монгол улсын Өмнийн говьд орших Оюу Толгойн зэс, алтны уурхайг ашиглах зорилготой төсөл юм. Оюу Толгой ХХК-ны (цаашид “Компани” гэх) хувьцааны 66%-ийг Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй “Туркойз Хилз Ресурс” Канадын компани эзэмшдэг бөгөөд үлдсэн 34%-ийг Монгол улсын засгийн газрыг төлөөлж төрийн өмчит Эрдэнэс Оюу Толгой ХХК эзэмшдэг. “Туркойз Хилз Ресурс” компанийн хамгийн том хувьцаа эзэмшигч нь олон улсын уул уурхайн Рио Тинто компани юм. Төсөл нь нийт 12 тэрбум ам. долларын хөрөнгө оруулалттай. Төслийн зээлийн санхүүжүүлтийн 4.4 тэрбум ам.долларын нэг хэсэг болгон ОУСК-аас оруулах хөрөнгө оруулалт нь ОУСК-ийн данснаас гаргах 400 сая ам.доллар хүртэлх “А” зэрэглэлийн зээл, мөн олон улсын арилжааны банкуудтай хамтран олгох 820.625 сая ам.доллар хүртэлх “Б” зэрэглэлийн зээлээс бүрдэнэ. ОУСК-ийн санхүүжилтээс гадна ОТХОБА нь гэрээг зөрчих, хөрөнгө хураах, шилжүүлэлтийн хязгаарлалт, дайн ба иргэний зөрчил мөргөлдөөний эрсдлээс хамгаалах 1 тэрбум ам.доллар хүртэлх баталгаа гаргаж байгаа юм.

Гомдлууд

2012 оны 10 дугаар сард төслийн талбайн ойролцоо амьдран, мал малладаг орон нутгийн нүүдэлчин малчдыг төлөөлөн 37 малчид “Оюу Толгойн Хяналт” үндэсний төрийн бус байгууллага (ТББ), “Говийн газар шороо” орон нутгийн ТББ-ын дэмжлэгтэйгээр ЭЗХНЗОГ-т гомдол гаргасан. Төсөл нутаг орных нь газар, усыг ашигласнаар тэдний нүүдлийн амьдрал ахуйг тасалдуулан, уламжлалт соёл, уугуул иргэдийн амьжиргаанд аюул учруулж байгаад гомдол

гаргагчид санаа зовж буйгаа дурьдсан байв. Гомдол гаргагчид Компанийн 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн үйл явц болон 2011 оны эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлтийн нөхөн олговрын үйл явц хангалттай бус, зохих ёсоор хийгдээгүй гэж үзэж байв. Ялангуяа ус хомс бүс нутагт усыг тогтвортой ашиглах асуудлын тухайд төслийн үйл ажиллагаа зүй зохистой гэдэгт эргэлзэж буйгаа илэрхийлсэн.

2013 оны 2 дугаар сард нутгийн долоон малчид Өмнөговь дахь Оюу Толгой төслийн хүрээнд Ундай голын гольдролыг өөрчилсний улмаас үүссэн нөлөөллийн асуудлаар хоёр дахь гомдлыг ОТ Хяналт, Говийн Газар Шороо ТББ-уудын дэмжлэгтэйгээр гаргасан болно. Голын гольдролыг өөрчлөх нь тэдний нүүдлийн ахуй, амьжиргаанд аюул учруулна гэж үзэж буйгаа илэрхийлсэн. Тэд ялангуяа ийнхүү гольдролыг өөрчилснөөр хэд хэдэн усан хангамжийн системийг ширгээж, бэлчээрийн үржил шимийг муутган, ой модны усан хангамжийг татруулах бөгөөд түүнчлэн энэ голыг хүн зон тахин шүтдэг тул соёл заншилд ч нөлөөлнө хэмээн санаа нь зовниж байна гэсэн юм.

ЭЗХНЗОГ-ЫН ҮНЭЛГЭЭ

Тус хоёр гомдлыг шалгуурыг хангасан хэмээн хүлээн авсны дараа ЭЗХНЗОГ-ын баг 2012 оны 12 дугаар сар, 2013 оны 3 дугаар сард хоёр гомдолд үнэлгээ хийхээр хэд хэдэн удаа Монгол улсад ажиллав. Үнэлгээний шатанд ЭЗХНЗОГ гомдлыг зөвтгөх мөн чанарын тухай мэдээлэл цуглуулдаггүй, харин гомдол гаргагчдын дэвшүүлсэн асуудлуудыг тодруулах, гомдлын асуудлуудыг талууд шийдвэрлэх хүсэлтэй эсэх,

улмаар хэрхэн яаж шийдэлд хүрэх эрмэлзэлтэй байгааг олж тогтооход төвлөрдөг.

Үнэлгээний явцад оролцогч талуудтай хэлэлцсэний үндсэн дээр гомдол гаргагч болон компанийн аль аль нь ЭЗХНЗОГ-ын чиглүүлэгтэйгээр маргаан шийдвэрлэх сайн дурын ажиллагааны хүрээнд гомдолд дэвшүүлсэн асуудлуудыг шийдвэрлэхээр тохиролцов. Шүүхийн бус, сөргөлдсөн бус, төвийг сахисан хөндлөнгийн форумын хувьд ЭЗХНЗОГ-ын маргааныг шийдвэрлэх чиг үүрэг нь оролцогч талууд гомдлын асуудлаар бүх талуудын сэтгэлд нийцсэн харилцан хүлээн зөвшөөрөх шийдлийг олох үйл явцыг чиглүүлэхэд оршдог. Талууд хоёр гомдлыг нэгтгэн маргааныг хэлэлцээрийн аргаар шийдвэрлэх нэг үйл явцтай байхаар тохиролцов. Хоёр гомдол гаргасан малчид өөрсдийг нь уг үйл явцад төлөөлөх “Малчдын Төлөөлөгчдийн Баг”-ийг (МТБ) иргэдийн нийтийн хурлаар ардчилсан байдлаар сонгож байгууллаа.

МАРГААН ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦ


ЭЗХНЗОГ-ын баг нь 2013 оны 3 дугаар сараас компани болон Говийн Газар Шороо, ОТ Хяналт ТББ, түүнчлэн Аккаунтабилити Консул ба Банк Информейшн Центр (БИЦ) гэсэн олон улсын хоёр ТББ-уудын зөвлөлтэй Малчдын Төлөөлөгчдийн Багаар төлөөлүүлсэн нөлөөлөлд өртсөн малчдын хамтарсан уулзалтуудыг чиглүүлэн ажиллаж эхлэв. ЭЗХНЗОГ нь талуудад хэлэлцээр хийх, зөрчил маргааныг шийдвэрлэх, харилцааны ур чадварын чиглэлээр сургалт явууллаа. Эхний уулзалтуудын үр дүнд төслийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийн талаар мэдээлэл авах, дэвшүүлсэн асуудлаар сэдэвчилсэн уулзалт зохион байгуулах, төслийн талбайд нэвтрэх боломж олгох зэрэг МТБ-ийн хүсэлтийг компани хүлээн авсан юм. Улмаар талууд усны гурван гол эх үүсвэрт Төслөөс учруулж буй нөлөөлөл, цаашид малчдын бэлчээр, усны хүртээмж, усны чанарт ямар үр дагавар авчрахыг үнэлэх баримтыг хамтран олж тогтоох үйл явцын¹ хүрээнд Хөндлөнгийн Шинжээчдийн Баг ажиллуулахаар тохиров. 2014

¹ Баримтыг Хамтран Олж Тогтоох (БХОТ) үйл явц нь холбогдох маргаантай баримт, шинжээчдийн өөр өөр санал дүгнэлт эсвэл шинжлэх ухааны маргаантай мэдээллийг зөрчил маргаантай байгаа талууд мэргэжлийн шинжээч, судлаачидтай хамтран тодруулах хамтарсан үйл явц юм. Ихэвчлэн талууд маргаантай асуудал болон шинжээчдийг

онд талууд Ханбогд сумын засаг захиргааг маргаан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах хүсэлт гаргахаар тохиролцсон юм.

“Бид аль нэг тал, хэн нэгэн хувь хүнрүү чичлэх биш - асуудлаа харж гарц гаргалгаагаа хэлэлцэн зөвшилцөж зөвлөлөөрөө асуудлыг шийдэж чаддаг болж байна.”

Л. Батцэнгэл, Малчдын Төлөөлөл, Гавилууд Баг, Ханбогд сум



Малчдын Төлөөлөгчдийн Баг (МТБ) 2013 оны 3-р сард хэлэлцээрийн ур чадварын чадавх бэхжүүлэх сургалтанд оролцож байгаа нь



Малчид, ОТ Хяналт ТББ компанийн төлөөлөгчдийн хамт уурхайн талбайд, 2014 оны 11-р сард

ажиллуулах цар хүрээг хамтран тодорхойлж, шинжээчдийг хамтран сонгон шалгаруулж, үйл явцын загварыг хамтран боловсруулж, баримтыг олж тогтоох үйл явцад хамтран оролцдог. Баримтыг Хамтран Олж Тогтоох үйл явц, ЭЗХНЗОГ, Практик үйл ажиллагааны эргэцүүлэл 3-ыг (2019) http://www.cao-dr-practice.org/reports/CAO_3_JointFactFinding.pdf хаягаас үзнэ үү. (2020 оны 4-р сарын 28-нд сүүлд нэвтэрч үзсэн)

Талууд хоёр жил гаруй хэлэлцэж, ярилцсаны эцэст 2015 оны 6 дугаар сард малчид, компани, Ханбогд сумын засаг захиргаанаас тус бүр ижил тооны төлөөллөөс бүрдэх Гурван Талт Зөвлөл /ГТЗ/ байгуулахаар шийдсэн. ГТЗ нь ЭЗХНЗОГ-т гаргасан гомдлуудад дурьдсан малчид, бэлчээр, устай холбоотой болон холбогдох бусад аливаа асуудлыг авч үзэх, хэлэлцэх, шийдвэрлэх, тэдгээрийн талаар мэдээлэл солилцох, тэдгээрт холбогдуулан санал, зөвлөмжүүд гаргах, түүнийг хэрэгжүүлэх, зохих эрх бүхий байгууллагуудад уламжлах үүрэгтэй.

Талууд 2015 оны 7-р сард малчдын амьжиргаанд Оюу Толгойн учруулж буй нөлөөлөл, Оюу Толгойн нөхөх олговрын үйл явц хир зохистой байсныг үнэлүүлэхээр баримтыг хамтран олж тогтоох хоёр дахь үйл явцыг эхлүүлэв. Талууд энэ ажлыг гүйцэтгэх ЖейЭсЭл Консалтинг, Оксфордын Их Сургууль ба Монгол Улсын ШУ-ны Академийн Газар зүй, Гео-Экологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаас бүрдсэн олон талт мэргэжлийн шинжээчдийн нэмэлт багийг сонгож ажиллуулав. Тус үнэлгээ гурван бүрэлдэхүүн хэсэгтэй байв. Үүнд: нэгдүгээрт малчдын бэлчээр, усны хүртээмж, чанарт гарсан өөрчлөлт; хоёрдугаарт малчин өрхүүдийн амьжиргаанд учирсан ерөнхий нөлөөлөл зэрэгт үнэлгээ хийх; эдгээр мэдээлэлд тулгуурлан гуравдахь үнэлгээ буюу төслийн 2004 оны нүүлгэн шилжүүлэлт, 2011 оны эдийн засгийн нөлөөллийн нөхөх олговрын үйл ажиллагаа зохистой байсан эсэхэд үнэлэлт өгөх юм. Тус үнэлгээнд Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн хоёр дахь шатны үнэлгээ мөн багтсан болно.

“Өнгөрсөн жилүүдийн Гурван талт зөвлөлийн яриа хэлэлцээг үр дүнтэй болгохын төлөө оролцсон бүх талууд хамтран ажиллаж чадсан. Оюу толгой компани энэ асуудалд эхнээсээ орон нутгийн талуудтай хамтран ажиллах, харилцан ойлголцох, түр зуурын биш харин талуудад урт хугацаанд үр өгөөжтэй байдлаар шийдэхэд шаардлагатай бүтээлч санал санаачлагыг дэмжихэд анхаарч, энэ байр сууриа тууштай баримталж ажилласан нь зөвшилцөлд хүргэхэд чухал хүчин зүйл болсон гэж үзэж байна.”

Г. Сугар, Орон нутгийн харилцааны ахлах менежер, ОТ ХХК

Үнэлгээний ажлыг жил хагасын хугацаанд гүйцэтгэсний дараа 2017 оны 1 дүгээр сард шинжээчид эцсийн тайлан, зөвлөмжүүдээ танилцуулсан. Талууд зөвлөмжүүдийг хүлээн авч тэдгээрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг хамтран боловсруулахаар тохирсон болно.



Компани, малчид, орон нутгийн засаг захиргаа ба хөндлөнгийн шинжээчид баримтыг хамтран олж тогтоох (БХОТ) үйл явцад оролцож байна, 2016 оны 2-р сар,



Олон Талт Мэргэжлийн Шинжээчдийн Багийн шинжээчид баримтыг хамтран олж тогтоох үйл явцын хүрээнд малчидтай уулзаж байна, 2016 оны 5-р сар

МАРГААНЫГ ШИЙДВЭРЛЭХ ҮЙЛ ЯВЦЫН ҮР ДҮН

Талууд 2017 оны 5 дугаар сард Ундай голын голидролын өөрчлөлт болон 2004, 2011 оны нөхөн олговрын үйл явцтай холбоотой асуудлаар гаргасан гомдлуудыг шийдвэрлэх хоёр гэрээг эцэслэн байгуулав. Гомдлуудыг шийдвэрлэхэд олон талт мэргэжлийн шинжээчдийн багийн

хийсэн үнэлгээ, Ундай голын голидролын өөрчлөлтийн шууд бус нөлөөллийн талаар Хөндлөнгийн Шинжээчдийн Багийн хийсэн 1, 2-р шатны судалгаа чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Эдгээр судалгааны зөвлөмжүүдийн үр дүнд ГТЗ нь гомдлуудыг шийдвэрлэхэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэх ажлыг тохиролцсон юм.

Гомдлыг барагдуулах хоёр гэрээнд бэлчээр, ус, нөхөн олговор, Ундай голын асуудлаар нийтдээ 60 гаруй асуудлыг хэрэгжүүлэх тохиролцоонд хүрчээ:

- 2004 оны нүүлгэн шилжүүлэлтийн үйл явцын арга барил зохистой байж чадаагүйг Компани хүлээн зөвшөөрч, 2004 онд нүүлгэсэн өрхүүдтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхийн тулд ГТЗ-тэй хамтран ажиллахаар тохиров;
- ГТЗ нь 2004, 2011 оны нөхөн олговрын үйл явцтай холбогдуулан малчин өрхүүдийн өргөдөл хүсэлтийг хүлээн авч тохирсон шалгуурын дагуу үнэлэх ‘Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо’-ны үүрэг гүйцэтгэж ажиллах;
- Компани 2004, 2011 оны нөхөн олговрын үйл явцын гэрээнүүдийн нууцлалын заалтыг цуцлахыг зөвшөөрсөн ба ингэснээр нөхөн олговор авсан хүмүүс өөрсдөө хүсвэл бусадтай энэхүү мэдээллээ хуваалцах боломжтой болов;
- Компани тогтвортой амьжиргааны төсөл, жижиг дунд үйлдвэрүүдэд (ЖДҮ) зориулсан чадавх бэхжүүлэх, малчин өрхийн хүүхдийн сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох, эрүүл мэндийн үйлчилгээг дэмжих зэрэг Ханбогд сумын нийт малчин өрхүүдэд зориулсан нийтийн нөхөн олговрын арга хэмжээг богино ба урт хугацаанд авч хэрэгжүүлэхээр тохирсон;
- Компани Ундай голын дагуу нутагладаг малчдад сургалтын төлбөрийн тэтгэлэг олгох, мэргэжлийн ур чадварын сургалт явуулах, мониторингийн цалинтай ажилд оролцох боломж олгохоор тохирсон; ба
- Бэлчээр, ус, мониторинг ба хамтын ажиллагаатай холбоотой нэмэлт үйл ажиллагааг хэрэгжүүлэх, тухайлбал Ханбогд сумын бэлчээрийн удирдлагын төлөвлөгөө боловсруулах; геофизикийн судалгааны дүнд тулгуурлан шинээр гүний худаг гаргах; орон нутгийн малчид, компаний хамтарсан хамтын

оролцооны мониторингийг сайжруулан хэрэгжүүлэх.

Талууд гэрээнүүдэд заасан бүх ажлуудыг бүрэн гүйцэд, үр дүнтэй, хангалттай хэрэгжүүлсэн тохиолдолд үндсэн гомдлуудад тусгасан асуудлууд шийдвэрлэгдсэн гэж үзнэ хэмээн талууд тохиров.

Талууд хийхээр тохирсон ажил тус бүрээр нарийн төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх хугацааг товлох ба тохирсон ажлуудын хэрэгжилтийг хангахад шаардлагатай хөрөнгө, санхүүжилтыг Компани хариуцахаар тохиролцсон болно.



Оюу Толгойн Үйл Ажиллагаа Хариуцсан Захирал малчдын төлөөлөлд уучлал хүссэн захидал гардуулав, 2015 оны 3-р сар



Гурван Талт Зөвлөлийг байгуулах Санамж Бичигт гарын үсэг зурах ёслолд ЭЗХНЗОГ-ын дэд ерөнхийлөгч оролцов, 2015 оны 6-р сар

Талууд гомдлыг барагдуулах хоёр гэрээг 2017 оны 5-р сард байгуулсан учраас эвлэрүүлэн зуучилж чиглүүлэх ажлыг дуусгавар болгон ЭЗХНЗОГ хоёр гомдлыг тохиролцооны хэрэгжилтэнд мониторинг хийж эхлэсэн юм. Талууд гэрээнүүдэд гарын үсэг зурсан өдрөөс хойш тэдгээрийн заалтын хэрэгжилтэнд ЭЗХНЗОГ-аар 12 сарын турш мониторинг хийлгэхээр тохиров.



Ханбогд сумын засаг дарга гэрээнд гарын үсэг зурав, 2017 оны 5-р сар

2017 оны 6 дугаар сард ГТЗ-ийн гишүүд ОУСК-иас Колумбийн Картахена хотод зохион байгуулсан “Тогтвортой Байдлын Туршлага - 2017” олон улсын бага хуралд оролцлоо. ГТЗ-ийг төлөөлөн Ханбогд сумын малчин, Ханбогд сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч, мөн Оюу Толгойн байгаль орчин ба орон нутгийн хамтын ажиллагаа, түншлэл хариуцсан менежер нар салбар хуралдаануудад гол илтгэгчээр оролцон, маргааныг шийдвэрлэхийн тулд хэрхэн хамтран ажилласан, ямар саад бэрхшээл тулгарч байсан талаарх туршлагаа хуваалцав. ЭЗХНЗОГ тухайн салбар хуралдааныг хөтөлж оролцсон болно.

ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН МОНИТОРИНГ

Гомдлыг барагдуулах гэрээнүүдэд гарын үсэг зурснаас хойш ГТЗ нь байнга хуралдаж хийхээр тохирсон ажлуудын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагаагаа үргэлжлүүлнэ. Гэрээгээр тохирсон ажлуудын эхний нэг жилийн хэрэгжилтийн явцыг ГТЗ-ийн гишүүд хэлэлцээд, хийхээр тохирсон нийт ажлуудын 70 гаруй хувь нь хэрэгжсэн эсвэл урт, богино хугацаанд хэрэгжиж байгаа гэж дүгнэжээ. ГТЗ цаашид тохирсон ажлын хэрэгжилтийг улам эрчимжүүлэхэд анхаарч

ажиллахаар тохирлоо. Мөн гомдлыг барагдуулах гэрээг амжилттай хэрэгжүүлснээр Ханбогд сумын малчин өрхүүдэд урт хугацаанд үр өгөөжөө өгөх болно гэдгийг дахин онцолсон байна.

2018 оны 12-р сарын байдлаар ГТЗ гэрээнд заасан ажлын хэрэгжилтийн явцыг дараах байдлаар тайлагнасан юм:

- Малчин өрхийн нийт 20 оюутан хүүхдэд их дээд сургууль төгстөл нь сургалтын тэтгэлэг олгох ажил хэрэгжиж 79,583,485 төгрөгийн (ойролцоогоор US\$32,187) сургалтын төлбөрийн санхүүжилт олгожээ;
- Нийтийн нөхөх олговрын хүрээнд “Малчдын худгийг сэргээгдэх эрчим хүчинд холбох” төслийн хүрээнд 10 худагт нарны энергээр ажилладаг ус өргүүрийн төхөөрөмж суурилуулан хүлээлгэн өгсөн ба уг төслийг 150 сая төгрөгөөр (ойролцоогоор US\$60,668) санхүүжүүлэн хэрэгжүүлжээ;
- Нөхөн Олговрын Нэхэмжлэлийн Хороо нь нийт 174 нэхэмжлэлийг хөөн хэлэлцэж үүнээс 114 нэхэмжлэлийг шалгуур хангасан гэж үзэж нөхөх олговор олгохоор дэмжиж, 60 нэхэмжлэлийг шалгуур хангаагүй тул татгалзаж шийдвэрлэв. Шалгуур хангасан 114 нэхэмжлэлд нийт 2,363,600,000 төгрөгний (ойролцоогоор US\$955,000) нөхөн төлбөр олгон шийдвэрлэжээ.
- Ханбогд сумын малчдын амьжиргааг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр харилцан тохиролцсоны хүрээнд долоон төслийг хэрэгжүүлэхээр тохирсон. Үүнд малчдын зах байгуулах болон малын гаралтай түүхий эдийг үйлдвэрлэгчдэд ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгох, малын тэжээлийн ургамал тариалах, мал нядалгааны зам барьж байнгын ажиллагаатай болгох, худаг засварын баг байгуулах, хороо засварын баг байгуулах гэх мэт төслүүд багтсан. Тус тайланг бэлтгэж байх үед эдгээр төслүүдийн олонхи нь хэрэгжилтийн дөнгөж анхан шат буюу техник эдийн засгийн үнэлгээний шатанд явж байв.
- Байгаль орчны төрөл бүрийн мониторинг хийх “Мөнх Ногоон Галба” шинэ ТББ байгуулагдан ажиллаж байна.

Гэрээнд заасны дагуу 2017 оны 10 дугаар сард Компани 2011 оны эдийн засгийн нөхөн олговрын үйл ажиллагааны Үр дүнгийн үнэлгээ

хийх хөндлөнгийн шинжээчдийг ажиллуулав. Энэ нь эдийн засгийн нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох ажиллагаа, малчдын амьжиргааг нөхөн сэргээх үүрэг амлалтаа Компани хир биелүүлсэн үр дүнг үнэлэх зорилготой юм.

Үнэлгээг хийхдээ уурхайн талбайд болон уурхайн талбайн эргэн тойронд хээрийн судалгаа хийн, Малчдын Төлөөлөгчдийн Баг, Оюу Толгой, орон нутгийн засаг захиргаа, иргэний нийгмийн төлөөлөл болон ЭЗХНЗОГ-тай ярилцлага хийсэн байна. Үр дүнгийн үнэлгээний тайлангийн төслийг Гурван Талт Зөвлөлийн хурлаар хэд хэдэн удаа хэлэлцүүлжээ. Үр дүнгийн үнэлгээнд санал болгосон зөвлөмжүүдийн хэрэгжилтийг Компани хангаж ажиллах үүрэг хүлээсэн ба тайлангийн дэлгэрэнгүй мэдээллийг Оюу Толгойн 2018 оны 9-р сарын Орон Нутгийн Нүүлгэн Шилжүүлэлтийн Төлөвлөгөөнд² оруулан олон нийтэд нээлттэй болгожээ.

Цаашид ГТЗ малчдын гомдлыг барагдуулах хоёр гэрээний хэрэгжилт болон холбогдох төслүүдийн хэрэгжилт, талуудын бүтээлч оролцооны чанарт дотоод мониторинг хийх хяналтын хурлыг улирал тутам хийхээр тохиров. Мөн хоёр гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн үнэлгээг жилд нэгээс доошгүй удаа хөндлөнгийн байгууллагаар хийлгэхээр тохиров.

ГТЗ-ийн гишүүд гомдлыг хэлэлцээрийн аргаар шийдвэрлэх үйл явц ихээхэн үр өгөөжтэй байсныг цохон тэмдэглээд хамтдаа хичээж, харилцан зөвшилцөн ажилласнаар ГТЗ “нэг баг” болон ажиллаж чаддаг боллоо гэж дүгнэв. Мөн ГТЗ нь харилцан итгэлцэл бүхий орчинд нээлттэй, шударга, бүтээлч яриа хэлэлцээ явуулах механизмыг бүрдүүлээ гэж дүгнэсэн. Мөн энэхүү маргаан шийдвэрлэх ажиллагаа нь бүх талуудын идэвхтэй оролцоо түүний дотор Ханбогд сумын засаг захиргааны байнгын дэмжлэг туслалцаа, малчдын төлөөллийн тууштай шаргуу оролцоо, Оюу Толгой компанийн тасралтгүй дэмжлэг зүтгэлийн үр дүнд бий болсон гэдгийг гишүүд санал нэгтэй дүгнэлээ. Цаашид орон нутгийн харилцагч талуудын идэвхтэй, асуудалдаа төвлөрсөн оролцоог хангах замаар ЭЗХНЗОГ-ын үйл явцаас гадна бүх талууд итгэлцэл, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх нь чухал болохыг онцлон тэмдэглэлээ.

² https://www.ot.mn/media/ot/content/esia-audits/201911/2018_OT_Resettlement_Action_Plan_ENG.pdf -г үзнэ үү. (2020 оны 4-р сарын 21-нд сүүлд нэвтэрч үзсэн)



Гурван Талт Зөвлөл ба ЭЗХНЗОГ нь ОУСК-ийн Өмнөговийн Ус ба Уул Уурхайн Салбарын дугуй ширээний ярилцлагын үеэр бусад уул уурхайн компаниудтай туршлагаа хуваалцаж байгаа нь, 2016 оны 9-р сар

ГОМДЛЫГ ХААХ ХААЛТЫН УУЛЗАЛТ

ЭЗХНЗОГ болон ГТЗ нь 2019 оны 3-р сард Монгол улсын Ханбогд суманд гомдлуудыг албан ёсоор хаах хаалтын уулзалт, Улаанбаатар хотод мэдлэг туршлагаа хуваалцах бага хурлыг зохион байгуулсан болно. Тус бага хуралд хувийн хэвшил, иргэний нийгэм, засгийн газар, олон улсын хандивлагч, хөгжлийн түнш байгууллагууд оролцсон юм. ГТЗ нь ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагаанд³ оролцсон өөрсдийн туршлагын талаар [видео](#) хийж нийтэд танилцуулжээ.

ҮЙЛ ЯВЦААС АВСАН СУРГАМЖ, ОЙЛГОСОН ЗҮЙЛС



ЭЗХНЗОГ-ын эвлэрүүлэн зуучлагч талуудын хамтарсан хурлын үеэр, 2014 оны 12-р сар

³ https://youtu.be/_yiY6rgdRP0-г үзнэ үү. (2020 оны 4-р сарын 21-нд сүүлд нэвтэрч үзсэн)

Үндэсний эвлэрүүлэн зуучлагчтай байхын ач холбогдол

Маргааныг шийдвэрлэх үйл явц бүхий ихэнх гомдлуудын хувьд талуудын харьяалал бүхий улс орон эсвэл бүсэд ЭЗХНЗОГ нь үндэсний эвлэрүүлэн зуучлагчийг ихэнхдээ олж ажиллуулж чаддаг. Ингэснээр орон нутгийн соёл заншил, онцлог, хэлийг илүү сайн ойлгоход туслахын зэрэгцээ талууд эвлэрүүлэн зуучлагчтай харилцах, шаардлагатай үед эвлэрүүлэн зуучлагч бэлэн байх боломжийг бүрдүүлдэг. Оюу Толгойн гомдлын хувьд ЭЗХНЗОГ нь эхэндээ Монгол улсаас туршлагатай эвлэрүүлэн зуучлагч олж чадаагүй бөгөөд Киргиз Улсаас тэргүүн эвлэрүүлэн зуучлагчийг ажиллуулсан билээ. Харин маргааныг шийдвэрлэх үйл явцын эхэнд ЭЗХНЗОГ нь тэдэнд ажиллаж буй хэлмэрчдийн нэг нь өмнө нь уул уурхай болон тогтвортой байдлын чиглэлээр сургалт явуулж, бүлгийн хэлэлцүүлгийг хөтлөн чиглүүлж байсан туршлагатай болохыг олж мэдсэн нь азтай завшаан болсон юм. Киргиз болон Украин улсаас ирж ажиллаж буй ЭЗХНЗОГ-ын ахлах эвлэрүүлэн зуучлагчид Монголын эвлэрүүлэн зуучлагчийг дадлагажуулан сургаж хамтран эвлэрүүлэн зуучилж ажилласан бөгөөд удалгүй тэрээр эвлэрүүлэн зуучлагчийн албан ёсны сургалтанд хамрагдсан билээ. Улмаар Монголын эвлэрүүлэн зуучлагч нь маргааныг шийдвэрлэх үйл явцыг ихэнх үе шатанд ганцаараа эвлэрүүлэн зуучилж чадсан юм. Энэ нь орчуулга, хэлмэрчлэл хийх хэрэгцээ шаардлагыг бууруулж, Монгол эвлэрүүлэн зуучлагч талуудтай шууд харилцах боломжийг олгосон, талуудтай найрсаг харилцаа, итгэлцлийг бий болгох, соёл, зан заншлын эмзэг асуудалд зохистой хандах зэргээр маргааныг шийдвэрлэх үйл явц болон талуудын хувьд ихээхэн тустай хүчин зүйл болсон юм. Монголын эвлэрүүлэн зуучлагч нь олон улсад жишээ болохуйц мэргэжлийн өндөр түвшинд хөндлөнгийн байр сууринаас ажилласан бөгөөд эдүгээ тэрээ Монгол улс болон өөр бусад орнуудад бусад гомдлын кейсийг эвлэрүүлэн зуучилж ажиллаж байна. Үндэсний эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхжуулах, тэдний мэдлэг чадварыг бэхжүүлэх нь ЭЗХНЗОГ-ын маргааныг шийдвэрлэх үйл явцын нэгэн чухал салшгүй хэсэг мөн.

Баримтыг Хамтран Олж Тогтоох үйл явц (БХОТ)

Баримтыг Хамтран Олж Тогтоох үйл явц нь баримт нотолгооны талаар талууд маргаантай байгаа гомдлын хувьд зөрчил маргааныг

шийдвэрлэхэд тусладаг чухал хэрэгсэл мөн. Энэ гомдлын БХОТ ажил, олж тогтоосон ажиглалтууд нь талуудын санал зөрөлдөөнтэй асуудлын цар хүрээг илүү нарийвчлан судалж, хоёр гомдлыг шийдвэрлэхэд талууд мэдээлэлд-тулгуурлан шийдвэр гаргах боломжийг олгосон юм. Талууд харилцан тохиролцож, харилцан хариуцлага хүлээх замаар мэдээллийг хамтран цуглуулж, дүн шинжилгээ хийж, тайлбарлах арга замыг эрэлхийлэх боломжийг олгодог учраас ЭЗХНЗОГ нь БХОТ үйл явцыг маргааныг шийдвэрлэх хэд хэдэн кейст ашигласан байдаг. Энэхүү үйл явц нь бүх талууд ойлгож, итгэж болох баталгаатай мэдээлэлд тулгуурлан мэргэжлийн болон шинжлэх ухааны аливаа асуудлыг олж тогтоохын тулд талуудыг хамтран ажиллуулдаг. Тус үйл явц олон бүрэлдэхүүн хэсэгтэй байх нь бий. Тодруулбал өмнө нь нэг тал нь нөгөө талдаа өгөөгүй мэдээллийг олж авах, байгаа мэдээллийн үнэн зөв, хариуцлагатай байдлыг дүгнэх, эсвэл шинжлэх ухааны судалгаа хийх замаар шинэ мэдээллийг бий болгох зэрэг байж болно. Ихэнхдээ БХОТ үйл явцын үр дүнг маргааныг шийдвэрлэх үйл явцад оролцогч талууд эсвэл тэдэнд нөлөө үзүүлэх засгийн газар, иргэний нийгэм, бусад хувийн хэвшлийн компаниуд зэрэг бүх оролцогч талууд хариуцлагатай, итгэж болохуйц баримт хэмээн хүлээн зөвшөөрдөг.

“ГТЗ-ийн өнөөдрийн түвшинд амжилтанд хүргэсэн гол хүчин зүйл нь Малчдын Төлөөлөгчдийн Баг, тэдний зөвлөхүүд, Оюу Толгой, орон нутгийн засаг захиргаа, олон талт мэргэжлийн шинжээчдийн баг, Хөндлөнгийн шинжээчдийн баг ба ЭЗХНЗОГ-ын уйгагүй хөдөлмөр, хамтын ажиллагааны нийлбэр гэж харж байна.”

Ө. Баттогтох, Малчдын Төлөөлөл, Жавхлант Баг, Ханбогд сум

Орон нутгийн засаг захиргааны гүйцэтгэсэн үүрэг

ЭЗХНЗОГ-ын зуучлан чиглүүлж буй маргааныг шийдвэрлэх үйл явцын үндсэн гол талууд нь гомдол гаргагчид (нөлөөлөлд өртсөн иргэд, бүлэг) ба ОУСК/ОТХОБА-ийн харилцагч (эсвэл төсөл хэрэгжүүлэгч) байдаг. Монгол улс зэрэг олон орны гомдлуудад талууд маргаантай бүх асуудлыг өөрсдөө шийдвэрлэх боломжгүй, үйл явцад өөр бусад оролцогч талуудыг оролцохыг урих хэрэгцээ шаардлага байгааг ойлгодог. Монгол улсын хувьд

гомдлын үндсэн талууд шийдлийг олохын тулд Ханбогд сумын засаг захиргаан оролцуулах шаардлагатай болохыг ойлгож эвлэрүүлэн зуучлах үйл явцад оролцохыг хүсч орон нутгийн засаг захиргаанд хандахаар тохиролцсон. Орон нутгийн засаг захиргаа ч зөвшөөрч талууд харилцан тохиролцсон дэг, дүрмийн хүрээнд ажиллах Гурван Талт Зөвлөлийг байгуулсан билээ. Энэ нь орон нутгийн засаг захиргааны туршлага, нөөц бололцоог ашиглах, сумын хөгжлийн ерөнхий төлөвлөлттэй ажлаа уялдуулах, холбогдох зөвшөөрөл авах, үйл явц ба үр дүнг улам хариуцлагатай байх нөхцлийг бүрдүүлэхэд тусласан юм.



ГТЗ, Аккаунтабилити Консул, ОУСК-ийн төлөөлөгчид Колумба улсын Картахена хотод зохион байгуулсан ОУСК-ийн Тогтвортой Байдлын Туршлага бага хуралд оролцов – ЭЗХНЗОГ илтгэлийг хөтлөв, 2017 оны 6-р сар



Оюу Толгой компаний гүйцэтгэх захирал, ГТЗ-ийн гишүүд, ЭЗХНЗОГ-ын баг Улаанбаатар хотод зохион байгуулсан Мэдлэг Туршлагаа Хуваалцах Бага Хурлын үеэр, 2019 оны 3-р сар

Туршлагаа хуваалцсан нь

Өөрсдийн мэдлэг, туршлага, авсан сургамжаа дэлхийн бусад орнуудын компаниуд, иргэд олон нийт, засгийн газар, иргэний нийгэм болон холбогдох оролцогч талуудтай хуваалцах хүсэл эрмэлзлэлтэй байгаад нь Монгол улсын талуудад ЭЗХНЗОГ талархаж байна. ЭЗХНЗОГ-ын маргааныг шийдвэрлэх үйл явц нь төрөл бүрийн шалтгааны улмаас талуудын хүссэн нууцлалыг хангаж хамгаалах боломжийг олгодог учраас ЭЗХНЗОГ-ын олон гомдлын талаарх дэлгэрэнгүй мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаггүй. Монгол улсын талууд нь бусад уул уурхай, хөгжлийн төслүүдэд зориулан эвлэрүүлэн зуучлалын гэрээ, баримтыг хамтран олж тогтоох үйл явцын үр дүн, ГТЗ-ийн дүрэм, хурлын товч тэмдэглэлүүд зэрэг маш олон мэдээллийг олон нийтэд нээлттэй хуваалцаж, өөрсдийн сургамж, туршлагын талаар олон нийтэд хандах ярих хүсэлтэй байгаа нь бидний хувьд аз завшаантай явдал юм.

ГТЗ-ийн авсан сургамж

ГТЗ нь өөрийн авсан дараах сургамжийг тайланд тусгуулахаар ЭЗХНЗОГ-т илгээсэн юм:

- Бүтээлч харилцаа нь итгэлцэл дээр тогтдог бөгөөд талууд хувийн харилцаа бус, дүрэм журмаар зохицуулагдсан шударга, ил тод харилцаа итгэлийг бэхжүүлдэг гэдгийг ойлгосон.
- Тухайн асуудлыг “байхгүй болгох” зорилгоор түр зуурын, хялбар шийдэл олох нь үр дүнтэй байж чадахгүй. Харин талууд бүгд хүлээн зөвшөөрөхүйц зохистой шийдлийг олоход цаг хугацаа зарцуулах нь урт хугацаандаа илүү үр дүнтэй гэдгийг ойлгосон.
- Нээлттэй, үнэнч шударгаар харилцах – хүнд хэцүү асуудлуудын талаар нухацтай ярилцаж, урт хугацаанд хамтран ажиллах албан ёсны гэрээг байгуулж, хамтран хэрэгжүүлэх үүрэг хүлээх замаар харилцаагаа бэхжүүлэх нь чухал.
- Орон нутгийн иргэд, бүлгүүдийн зорилго, эрмэлзэл болон нутгийн нийгэм-соёлын нөхцлийг гүнзгий судлан ойлгосноор санаа зовж буй асуудлуудыг нь шийдвэрлэхэд шаардлагатай урьдчилсан нөхцөл болж, тогтвортой хөгжилд хүрэх боломжийг нь бүрдүүлдэг.

“Миний хувьд энэхүү үйл явцад орон нутгийн захиргааг төлөөлөн эхнээс нь оролцсон.... Гомдлыг шийдэх, олон талууд хамтран ажиллах талаар залуу хүний хувьд их олон зүйл сурсан.... олны эрх ашгийн төлөө өдийг хүртэл ажиллаж ирсэн малчдын идэвх зүтгэлийг би их өндрөөр үнэлдэг.... Бид ирээдүйгээ маш өөдрөгөөр төсөөлж байна. Бид цаг хугацааны явцад хамтдаа аливаа зөрчил маргааныг даван туулж олон үр дүнтэй ажлуудыг хийх болно. Бидний энэхүү туршлага Монгол улсдаа анхдагч болсон нь бахархууштай.”

Б. Алтангэрэл, Ханбогд сумын Байгаль Орчны Улсын Байцаагч

ОУСК ба ОТХОБА-ийн авсан сургамж

ОУСК нь өөрийн авсан дараах сургамжийг тайланд тусгуулахаар ЭЗХНЗОГ-т илгээсэн юм:

- **Баримтыг Хамтран Олж Тогтоох (БХОТ):** Төслийн нөлөөллийн талаар талуудын санал зөрөлдөөнтэй байсан асуудлаар харилцан хүлээн зөвшөөрөхүйц хариуцлагатай өгөгдөл, дүгнэлт гаргасан БХОТ үйл явц нь чухал үнэ цэнэтэй ажил байсныг ОУСК цохон тэмдэглэмээр байна.
- **Хамтын оролцоотой байгаль орчны мониторинг, үүнд усны мониторинг гэх мэт:** Жилд орох хур тунадасны хэмжээ, нутгийн ургамал, ан амьтны нөхцөл байдал асар их ялгаатай байдаг хүрээлэн буй хуурай орчинд төслийн нөлөөлөлд өртсөн иргэдэд зориулан хамтын оролцоотой байгаль орчны мониторингийн хөтөлбөр (ХОБОМХ) хэрэгжүүлэх нь эрсдлийг удирдах чухал хэрэгсэл болох юм. Ийм орчинд ялангуяа ус ба бэлчээрийн хүртээмжтэй бэлэн байдал нь төслийн нөлөөллөөс эсвэл байгалийн хувьсамтгай хүчин зүйлийн улмаас өөрчлөгдөж байгааг үнэлэхэд бэрхшээлтэй байдаг. Иймд зохих мэргэжлийн сургалтын дэмжлэгтэйгээр хангалттай нөөц бололцоо бүхий ХОБОМХ-ийн гүйцэтгэх үүрэг нэн чухал. ХОБОМХ нь шинжлэх ухааны өгөгдлийг хүртээмжтэй, ойлгогдохуйц байлгаж, итгэлцлийг бий болгоход тусална. Оюу Толгойн дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй ХОБОМХ-ийг өмнө дурдсан “Мөнх Ногоон Галба” орон нутгийн ТББ-т хариуцан ажиллуулахаар шилжүүлсэн нь хөтөлбөрийн

хүчин төгөлдөр, үндэслэлтэй байдлыг сайжруулж байгаа юм.

ОУСК-ийн Зөвлөх үйлчилгээ нь 2012-2016 оны хооронд Өмнөговь аймаг дахь уул уурхайн салбарт тогтвортой усны хэрэглээ, хамтын оролцоотой усны мониторингийг дэмжих хөтөлбөрийг хэрэгжүүлсэн юм.

- **Нүүлгэн шилжүүлэлт:** Малчдын амьжиргаанд үзүүлэх нөлөөллийг үнэлэх аргачлал, холбогдох нөхөн олговрын хөтөлбөрийн загварыг боловсруулахдаа хагас нүүдэлчин/ бэлчээрийн нүүдэлчдийн онцлог шинж чанарт шууд тулгуурлах ёстой юм байна. Түүнчлэн 2018 оны 7-р сард Оюу Толгойн хийсэн шиг амьжиргааг нөхөн сэргээсний дараах аудитыг хийх нь хэрэгжүүлсэн ажлууд хир үр дүнтэй байсныг баталгаажуулахад чухал юм байна. ОУСК нь Гүйцэтгэлийн Стандартуудыг нэвтрүүлснээс хойших туршлага сургамжиндаа тулгуурлан Нүүлгэн Шилжүүлэлтийн шинэ гарын авлага боловсруулсан бөгөөд амьжиргааг нөхөн сэргээх ажлын хэрэгжилтэнд үргэлжлүүлэн мониторинг хийнэ. Тус гарын авлагад ЭЗХНЗОГ-ын кейсүүдээс авсан сургамж, төслүүдийн туршлага, Газар чөлөөлөлт ба албадан нүүлгэн шилжүүлэлтийн тухай Гүйцэтгэлийн Стандарт 5-тай холбоотой хэрэгжүүлэх практик стратегиудыг тусгасан болно.
- **Оролцогч талуудын уулзалт:** Гомдол гарсны улмаас ОУСК нь төслийн нөлөөлөлд өртсөн иргэд, ТББ зэрэг оролцогч талуудаас шууд мэдээлэл сонсох оролцогч талуудын уулзалтыг тогтмол хийх шийдвэр гаргасан. ОУСК нь 2012 оны 12-р сар (үнэлгээний явцад), 2016 оны 4-р сар, 2017 оны 3-р сар, 2018 оны 9-р сар, 2019 оны 10-р сард Улаанбаатар хот болон Ханбогд суманд (Оюу Толгойн уурхайн талбайн ойролцоо) оролцогч талуудын уулзалтыг дөрвөн удаа хийлээ. ОУСК нь 2019 оны 3-р сард ЭЗХНЗОГ-ын гомдлыг хаах хаалтын хурал болон 2019 оны 5-р сард Дэлхийн Банкны Бүлгийн Гүйцэтгэх Захирлуудын бүлэг болон улс орнуудын оролцогч талуудын хамтарсан хуралд бусад оролцогч талуудын хамт оролцсон билээ. Уурхайн тогтмол хяналтын аялалын үеэр нөлөөлөлд өртсөн малчидтай ОУСК нь шууд уулзаж байгаа. ОУСК нь баталгаатай байх

хугацаандаа оролцогч талуудтай үргэлжлүүлэн идэвхтэй уулзана.

“Аливаа асуудлыг баримтанд үндэслэн нээлттэй ил тод хэлэлцэж, олны санаа бодлыг шингээсэн шийдвэрт хүрч, хэрэгжилтэнд хариуцлагатай хандах жишиг механизмыг бүрдүүлснээрээ бид хамтын амжилтанд хүрч чадлаа.”

Ш. Байгалмаа, Ерөнхий Менежер, Стратеги Олон Нийтийн Төсөл, ОТ ХХК

- **Нэгдмэл ажлын уялдаатай ажиллах чиг хандлага:** Ус, газар, биологийн төрөл зүйл зэрэгт нөлөөлсөн бодит эсвэл төсөөллийн нөлөөлөлтэй нарийн төвөгтэй төслүүдийн хувьд тэдгээр нөлөөллийг нэгдмэл цогц байдлаар удирдах шаардлагатай. Оюу Толгойн мэргэжлийн багуудын хооронд хамтран төлөвлөх, хамтран хэрэгжүүлэх явдлыг хэвшүүлэхийн тулд Оюу Толгойн орон нутгийн харилцаа, биологийн төрөл зүйл, усны багийн ажилтнуудаас бүрдсэн дотоодын экосистесийн үйлчилгээний ажлын хэсэг (ЭҮАХ) байгуулах чиглэлээр ОУСК нь Оюу Толгойтой хамтран ажиллалаа. ЭЗАХ нь бэлчээрийн удирдлага, оролцогч талуудын оролцоо, биологийн төрөл зүйлийн нөхвөр, экосистемийн үйлчилгээ зэрэг ус, газар, биологийн төрөл зүйлтэй холбоотой мэргэжлийн асуудлаар ажлаа уялдуулах, удирдах, шийдвэр гаргах форум хэлбэрээр ажиллана. Мэргэжлийн олон хэлтсийг нэгтгэн ажиллуулах арга барилын үндсэн зарчим нь ялангуяа нийгмийн болон биологийн төрөл зүйлийн асуудалд байнга холбогдож уялдаж байгаа учраас ОУСК-ийн одоо хэрэгжиж буй төслүүдэд өргөн нэвтрүүлэхийг уриалж байгаа юм. Оюу Толгойд ийнхүү тусгай ажлын хэсэг байгуулах бүтэц нь Оюу Толгойн баг хамт олны хүрэлцээ, тэдний гаргаж буй хүчин чармайлтыг улам төвөгтэй болгож байна. Үүнийг илүү хялбар арга хэрэгслээр шийдвэрлэх боломжтой (жишээ нь нийгмийн болон биологийн төрөл зүйл/байгаль орчны баг тогтмол уулзах).

ДҮГНЭЛТ БА ДАРААГИЙН АЛХАМ

Эвлэрүүлэн зуучилсан гомдлыг барагдуулах гэрээний хэрэгжилтэнд талуудын сэтгэлд нийцтэл хугацаанд мониторинг хийсний дараа эдгээр хоёр гомдлын маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаан дахь оролцоогоо ЭЗХНЗОГ нь дуусгавар болголоо. ГТЗ нь харилцан тохирсон томоохон ажлууд болон тогтвортой амьжиргааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх хэд хэдэн төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх юм. Үүнд:

- Малчны зах байгуулах буюу малын гаралтай түүхий эдийг үйлдвэрлэгчдэд ханган нийлүүлэлтийн сүлжээг бий болгоход дэмжлэг үзүүлэх төсөл
- Мал нядалгааны шугам барих, байнгын ажиллагаатай болох
- Малчдад хүрэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах төсөл
- Амьдрах ухааны цогц сургалтын төсөл
- Худаг, хороо засварын баг байгуулах төсөл
- Ханбогд сум харилцаа холбооны сүлжээний хамрагдалтыг нэмэгдүүлэхийн тулд Юнителийн сүлжээний антеныг Гавилууд багт байрлуулах ажил
- Залуу малчдад дэмжлэг туслалцаа үзүүлэх, “Залуу малчин” төсөл
- Хиймэл нуур цөөрөм, хур борооны ус цуглуулах хөв байгуулах
- Мал аж ахуйн салбарын хөгжлийн суурь болох бэлчээр, усны нөөцийн цогц судалгаа хийж тэдгээрт үндэслэн Ханбогд сумын бэлчээр ашиглалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх
- Мал маллагааны уламжлалт арга барилыг сэргээх, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, мэргэжилтэнүүдийг чадвахжуулах
- Малыг эрүүл мэнд, үүлдэрлэг байдлыг сайжруулах, ашиг шимийг нэмэгдүүлэх
- Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх үйлдвэрүүдийг хөгжүүлэх.

“ГТЗ-ийн нийт гишүүд Малчдын гомдол барагдуулах Омбудсмений газрын эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааг амжилттай дуусгаж, Зөвлөл цаашид бие даан ажиллах ур чадварыг бэхжүүлж, олон улсад жишээ болохуйц маргаан шийдэх ажиллагааг чин сэтгэлээсээ хичээл зүтгэл гаргаж мэргэжлийн өндөр түвшинд чиглүүлсэн ЭЗХНЗОГ-ын багт чин сэтгэлээс талархлаа илэрхийлж, амжилт хүсч байна.”

Гурван Талт Зөвлөлийн Мэдэгдэл, 2019 оны 3-р сар

ОУСК болон ОТХОБА нь хэрэгжиж буй төслийн хяналтын хүрээнд эвлэрүүлэн зуучилсан гомдлыг барагдуулах гэрээнд заасан ажлуудын хэрэгжилтийг цаашид үргэлжлүүлэн мониторинг хийх юм.

Энэ үйл явцтай холбоотой холбогдох бүх баримт бичгүүд үүнд Гурван Талт Зөвлөлийн хамтарсан мэдэгдлүүд, талуудын гарын үсэг зурсан гэрээ зэргийг ЭЗХНЗОГ-ын цахим хуудаснаас үзэх боломжтой www.cao-ombudsman.org